

# Таваарын зах зээлийн долоо хоногийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.01.03

Нүүрс  
Төмрийн хүдэр  
Зэс



# НҮҮРСНИЙ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 01-р сарын 03

## Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн долоо хоногийн баасан гарагт буюу 12 сарын 31 өдөр БНХАУ-ын Статистикийн ерөнхий хорооноос PMI /Purchasing Managers Index/ 12 сарын тоон мэдээллийг гаргалаа. 12 сард аж үйлдвэрийн салбарын PMI индекс шинжээчдийн таамаглалыг эвдэж 50.3 хувьтай гарсан бөгөөд энэ нь 7 сараас хойшхи хамгийн өндөр үзүүлэлт юм.

Аж үйлдвэрийн салбарын PMI индекс үзүүлэлт сайн гарсан нь аж үйлдвэрийн идэвхижилт сайжирч байгааг илэрхийлж байгаа бөгөөд тус эерэг мэдээтэй холбоотой 12 сарын 31 өдөр коксжих нүүрсний фьючерс ханш 1.48 хувиар, металургийн коксын ханш 0.39 хувиар тус тус өссөн байна.

2021 оны сүүлийн саруудад агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой гангийн болон коксжуулах үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг бууруулаад байсан бол 2022 оны 01 сарын 01 өдрөөс эхлэн БНХАУ-ын гангийн үйлдвэрүүд болон коксжуулах үйлдвэрүүд үйлдвэрийн хүчин хэвийн түвшинд үргэлжлүүлэхээр болсон байна.



12 сарын 31 өдөр БНХАУ-ын үндэсний хөгжил шинэчлэлийн хорооноос 2022 оны 01 сарын 01 өдрөөс эхлэн өвлийн олимпын үеэр эрчим хүчний эрэлтийг тогтвортой барих үүднээс БНХАУ-ын хойд хэсэг ялангуяа Hebei мужид нүүрсний агуулхын нөөцөө 30 хоногт хүрэхүйц хэмжээнд хүргэх буюу эрс нэмэгдүүлэх үүрэг даалгаварыг өгсөн байна.

2022 оны 02 сарын 04 өдөр БНХАУ-д өвлийн олимп эхлэх бөгөөд өвлийн олимпын дараагаар сүүлийн саруудад унаад байсан гангийн компаниуд болон нүүрс олборлогч компаниудын хувьцааны ханш сэргэх төлөвтэй байгаа гэж олон улсын шинжээчид үзэж байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



# ТӨМРИЙН ХҮДРИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 01-р сарын 03

## Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн долоо хоногийн даваа гарагт Далианы таваарын биржийн төмрийн хүдрийн 5 сарын фьючерс гэрээний ханш даваа гарагт 713.5 дээр нээгдсэн бол баасан гарагт 674 юань дээр хаагдсанаар 5.8 хувийн уналт үзүүлээ.

Өнгөрсөн баасан гарагт China Steel Logistics Committee (CSLC) БНХАУ-ын гангийн салбарын 12 сарын PMI /Purchasing managers index/ тоон мэдээллийг олон нийтэд зарласан бөгөөд өмнөх сараас 2.1 хувиар өндөр буюу 38.7 хувьтай гарсан байна. Үүнд гангийн салбарын PMI индексийн дэд индексүүд тэр дундаа үйлдвэрлэлийн индекс 2.4 хувиар уналттай гарсан бол шинэ захиалга 2.2 хувиар, экспортын захиалгын индекс 1.5 хувиар тус тус өссөн байна.

Үүнээс үзэхэд 12 сард агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой гангийн үйлдвэрлэлийг бууруулсанч шинэ захиалга, экспортын захиалгын индексүүд өсөлттэй гарсан нь эрэлт өндөр байгааг харуулж байна.

Published on Investing.com, 3/Jan/2022 - 6:08:32 GMT, Powered by TradingView.  
Iron ore fines 62% Fe CFR Futures, China, DCE:IOK2, D



Citic Futures-ийн шинжээч Zeng Ning-ийн үзэж байгаагаар Бээжингийн өвлийн олимпын дуустал төмрийн хүдрийн эрэлт сул байх төлөвтэй байна. Өвлийн олимпын үеэр агаарын бохирдлыг бага байлгах мөн барилгын салбарын уналт нь 2022 оны эхний улиралд төмрийн хүдрийн эрэлт бага байх гол хүчин зүйл хэмээн үзэж байгаа юм байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



# ЗЭСИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Долоо хоногийн онцлох үйл явдал

2022 оны 1-р сарын 3

Өнгөрсөн долоо хоногийн даваа гарагт Шанхайн таваарын биржийн зэсийн катодын ханш 69,410 юань дээр нээгдэж баасан гарагт 69,940 юань дээр хаагдсанаар 0.3 хувийн өсөлт үзүүлээ.

Баасан гарагт БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын PMI индекс шинжээчдийн таамаглалыг эвдэж 50.3 хувийн өсөлттэй гарсантай холбоотой таваарын биржүүдийн зэсийн катодын гэрээний ханшууд өсөлттэй хаагдлаа. Үүнд Шанхайн таваарын биржийн ханш 0.03 хувиар Comex 1.61 хувь тус тус өссөн байна. Ингэснээр 2021 онд таваарын биржүүдийн зэсийн катодын фьючерс ханшууд дунджаар 20 хувийн өсөлт үзүүлээ.

Published on Investing.com, 3/Jan/2022 - 6:34:51 GMT, Powered by TradingView.  
Copper Futures, China, SHFE:SCF1, D



Дэлхийн хамгийн том зэс олборлогч улс болох Чили улсын төрийн өмчит Codelco компанийн удирдлагууд өнгөрсөн долоо хоногийн лхагва гарагт хийсэн хэвлэлийн хуралд 2022 онд Зүүн өмнөд Азийн улс орнуудтай урт хугацааны гэрээ хийж байгаагаа мэдэгдлээ. Ингэхдээ 2022 онд тус бүс нутагт зэсийн борлуулалтаа эрс нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдсэн боловч тодорхой нарийвчилсан тоо баримтаар хангасангүй.

Codelco-ийн маркетингийн дэд ерөнхийлөгч Carlos Alvarado-ийн хэлж байгаагаар дараагийн 20 жилд Зүүн Өмнөд Азид зэсийн эрэлт өндөр байх төлөвтэй байгаа бөгөөд цар тахлын дараагаар дэлхийн эдийн засаг цаашид сэргэх төлөвтэй байгаа нь зэсийн эрэлт өсөж цаашлаад ханшийг өсгөх эерэг хандлагатай байгаа хэмээн мэдэгдсэн байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



## Холбоо барих

---



**Т.Азтүшиг**  
Ахлах шинжээч

aztushig@golomtcapital.com  
9997-0303

---

**Golomt Capital®**

---

